

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2026.01.06

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа үр дүнг үнэлэх журам”, 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн тайланд хяналт шинжилгээ хийж, дүнг танилцуулж байна.

Баян-Өлгий аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 25 арга хэмжээ тусган дараах байдлаар хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ							Дундаж Хувь
	/-/	0	20-30	50-69	70-89	90	100	
25		1	1	6	2	-	15	82.4

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээ	Үнэлгээ /хувь/	Биелэлт, тайлбар
1	1.2.Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд өгөгдлийн шинжилгээ хийх	50	Тодорхой арга хэмжээ авч ажилласан хэдий ч өгөгдлийн шинжилгээний тайлан ирүүлээгүй.
2	2.3.Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх	50	Тухайн нэгж нь Улсын бүртгэлийн байгууллагын ү/а-нд эрсдэлийн үнэлгээ хийхгүй /Шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөж, тайлагнах/
3	2.7.Үндэсний энгийн цахим гадаад паспортын үйлчилгээг сумаасаа үзүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах	50	Тодорхой арга хэмжээ авсан хэдий ч хүрэх түвшинд хүрээгүй. /Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй. нотломжгүй /
4	2.8.Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/ -аар үзүүлэх бүртгэлийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	53.9	Тодорхой арга хэмжээ авсан хэдий ч хүрэх түвшинд хүрээгүй. /Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй /
5	2.10.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах	20	Тодорхой арга хэмжээ авсан хэдий ч хүрэх түвшинд хүрээгүй. /Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй /
6	5.1.Хэлтсийн 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэн ажиллах. /2.6.2.3./	50	Тодорхой арга хэмжээ авсан хэдий ч хүрэх түвшинд хүрээгүй. /Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй /
7	7.2.Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар	0	УБЕГ-т ирүүлсэн 250 албан бичгээс хос бичгээр хөтлөгдөж

тогтоолын хэрэгжилтийг ханган албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхлэх	ирүүлсэн албан бичиг 1 байна. /Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрээгүй./
--	--

Дүгнэлт, зөвлөмж

Баян-Өлгий аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн тайланд хяналт шинжилгээ хийж, жилийн эцсийн байдлаар биелэлт **82.4** хувьтай. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа үр дүнг үнэлэх журам”-ын 2.5.2 төлөвлөгөөний хэрэгжилт 70-85 хүртэл хувь бол “хангалттай” (*шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах*) үнэлэгдэв.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны А/236 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтээр дүгнэж, 2025 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүн **71.4** хувиар дүгнэгдэв.

Үзүүлэлт		Оноо	Жин
1	2	3	4
Нэгжийн чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Улсын бүртгэлийн хууль, дүрэм журмын дагуу бүртгэл үнэн зөв хөтөлж, хяналт тавих, зохион байгуулах /30 оноо/	12	0.12
Төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилтийн үнэлгээ	1.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт /20оноо/	16.5	0.24
	2.Улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа бусад арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /5 оноо/	2	
	3.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, Даргын зөвлөл, Шуурхай хурлын шийдвэрийн хэрэгжилт /5 оноо/	4.6	
Санхүүгийн үйл ажиллагааны үнэлгээ	1.Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулж, өр, авлагагүй ажилласан байдал /2 оноо/	2	0.10
	2.Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, холбогдох тодруулга, материалын хамт хуульд заасан хугацаанд хүргүүлсэн байдал /2 оноо/	1.9	
	3.Үнэт цаас, маягтын тооллого хийж, тайлан хүргүүлсэн байдал /2 оноо/	2	
	4.Өмч хөрөнгийн тооллого хийсэн байдал /1 оноо/	1	
	5.Аудитын дүгнэлт, зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилт /2 оноо/	2	
	6.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу явуулсан, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний талаарх мэдээллийг байршуулсан байдал /1 оноо/	1	
Нэгжийн ил тод байдлын үнэлгээ	1.Нэгжийн ил тод нээлттэй байдлын үнэлгээ /10 оноо/	9	0.9
	1.Идэвх, санаачлаг, шинэлэг ажил /5 оноо/	3.5	0.17

Бусад чиглэлээр өгсөн үнэлгээ	2.Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал /1 оноо/	1	
	3.Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт /2 оноо/	1.9	
	4.Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилт /2 оноо/	2	
	5.Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээ /5 оноо/	4	
	6.Сургалт, семинар зохион байгуулсан болон хамрагдсан байдал /2.5 оноо/	2.5	
	7.Тайлан мэдээг үнэн зөв, гүйцэд, хугацаанд нь ирүүлсэн байдал, үйл ажиллагаа тайлагнасан байдал, ажлын уялдаа холбоо /2.5 оноо/	2.5	
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		71.4	0.71

Зөвлөмж

1. Засгийн газрын 2020 оны 2017 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.4 (тухайн жилийн хүрэх түвшинд хүрч чадаагүй зорилт, арга хэмжээний шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, эрх бүхий байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн цаашид үргэлжлүүлэх шаардлагатай арга хэмжээг дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.)-д заасны дагуу нэгжийн дарга нар 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өөрийн нэгжид хамаарах тасарсан болон хэрэгжилт хангалтгүй, дараа онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тусгаж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрч ажиллах;
2. Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн өөрийн нэгжид хамаарах зорилт арга хэмжээ, заалт бүрийн гүйцэтгэлд чиглэсэн нарийвчилсан төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллах;
3. Гүйцэтгэлийн тайланг шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнгийн тодорхойлолтоор нотломжид суурилан тайлагнаж, нотломжийн хамт ирүүлж байх;
4. Тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг үнэн зөв, тодорхой дурдаж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг ямагт харгалзан үзэж тайлагнахыг анхаарах; (шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж тайлагнаагүй нь үнэлгээ алдах гол үзүүлэлт болж байна.)
5. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан нийтлэг болон тусгай шаардлагыг хангах;

ХУУЛЬ ЗҮЙ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС